



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/42

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Сангийн сайдын 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн болон Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгө оруулалтаар хийгдэж буй гүн өрмийн худаг гаргах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд

Д.Мөнх-Эрдэнэ

(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Т.Бат-Эрдэнэ

(Сүмбэр сумын Засаг дарга)

Б.Болд-Эрдэнэ

(Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Сарантуяа

(Умард говийн гүвээт халхын дундад талын усны сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн) /Зөвшилцсөнөөр/

Н.Ганаа

(“Ус Ундрах” ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:

Ц.Уранбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Дээрх ажлыг холбогдох хууль, тогтоомж, техникийн тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, тавигдсан шаардлагын дагуу шалган хүлээн авч, үр дүнг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ц.Уранбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ